

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

2022.12.02

Алтай хот

## **НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны 11 дүгээр сарын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоолын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрт туссан орон нутагт хэрэгжүүлэх заалтын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг сайжруулах дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангахад чиглэгдлээ.

## **ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан ([new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn))-д байршуулсан 2022 оны 11 дүгээр сарын хэрэгжилтийг тайлагнах Засгийн газрын 8 тогтоолын 10, Засгийн газрын 11 хуралдааны тэмдэглэлийн 14, Засгийн газрын 5 албан даалгаврын 7, нийт 24 шийдвэрийн 31 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хэрэгжилтийн үнэлгээг авч үзвэл: нийт 31 заалтын 16 нь “Бүрэн хэрэгжсэн” буюу 100 хувь, 11 нь “Хэрэгжих шатанд” буюу 70 хувь, 4 нь “Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувьтай үнэлэгдэж, хэрэгжилтийн дундаж 80.32 хувьтай байна.

## **ГУРАВ. ДҮГНЭЛТ**

1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны 11 дүгээр сарын хэрэгжилт 80.32 хувьтай байна.

2.Засгийн газрын 1 тогтоолын 2, Засгийн газрын 2 хуралдааны тэмдэглэлийн 2, нийт 3 шийдвэрийн 4 заалт “Хэрэгжилт хангалтгүй” буюу 30 хувийн хэрэгжилттэй байна. Үүнд:

-Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээс бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авах (Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол)

- Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх (Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол)

- Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан

Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах ( Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022 оны 28 дугаар тогтоол)

- Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авах (Засгийн газрын хуралдааны 2022 оны 42 дугаар тэмдэглэл)

#### **ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

**НЭГ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТЭСТ:**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны 11 дүгээр сарын тайлангаар 30 хувьтай буюу “хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 3, 9 дүгээр заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах;

**ХОЁР. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ:**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2022 оны 11 дүгээр сарын сарын тайлангаар 30 хувьтай буюу “хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 3, 9 дүгээр заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах;

**ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС, ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ:**

1. Засгийн газрын хуралдааны 2022 оны 42 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах;

**ДӨРӨВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС, УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭСТ:**

1.Засгийн газрын хуралдааны 2022 оны 28 дугаар тэмдэглэлээр өгөгдсөн бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох ажлыг эрчимжүүлэх;

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**